

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ

/2015 оны 3-р сарын 18-наас 2015 оны 4-р сарын 15-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	III/18	III/25	IV/1	IV/8	IV/15
1	Гурил, I зэрэг, кг	1100	1100	1100	1100	1100
2	Хонины мах, кг/ ястай/	6800	6800	7000	7500	7500
3	Үхрийн мах, кг /ястай/	8000	8000	8000	8500	8500
4	Ямааны мах /ястай /	5500	5500	5500	6000	6000
5	Элсэн чихэр, кг	1500	1500	1500	1500	1500
6	Цагаан будаа, кг	2200	2200	2250	2250	2300
7	Шингэн сүү, л	1500	1500	1500	1500	1500
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	зарагдаагүй	62000	60000	50000	51000
9	- Бор ноолуур	зарагдаагүй	62000	60000	50000	51000
10	Бензин, А-80, 1 литр	1570	1570	1570	1570	1570
11	Бензин, А-92, 1 литр	1690	1690	1690	1690	1690
12	Дизелийн түлш, 1 литр	1790	1790	1790	1790	1790

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2014 оны 3-р сарын 18-наас 2015 оны 4-р сарын 15-ны хооронд Алтан тариа ХК-ийн 1-р гурил элсэн чихэр, шингэн сүү, шатахууны үнэ тогтвортой байв.

Махны үнэ. 3-р сарын 25-ыг хүртэл хонины ястай мах 1 кг нь 6800 төгрөг байсан бол 4-р сарын 1-нд өмнөх 7 хоногоос 2.9 хувь буюу 200 төгрөгөөр, 4-р сарын 8-нд өмнөх долоо хоногоос 7.1 хувь буюу 500 төгрөгөөр тус тус өсөв. Үхрийн ястай мах 1 кг нь 4-р сарын 1-ийг хүртэл 8000 төгрөг байсан бол 4-р сарын 8-нд өмнөх долоо хоногоос 6.25 хувиар, ямааны ястай мах 1 кг нь 5500 төгрөгийн ханштай байсан бол 4-р сарын 8-нд өмнөх долоо хоногоос 9.1 хувиар нэмэгдлээ.

Гурил, элсэн чихэр, цагаан будаа. Алтан тариа ХК-ын 1-р гурил, элсэн чихрийн үнэ сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой байлаа. Цагаан будааны үнэ сүүлийн хоёр долоо хоногт 100 төгрөгөөр өсч 4-р сарын 15-нд 2300 төгрөг болов.

Шингэн сүү. Шингэн сүүний сүүлийн 5 долоо хоногийн турш 1500 төгрөгийн ханштай байна.

Ноолуур. 3-р сарын 25-наас ноолуурын арилжаа 1 кг нь 62000 төгрөгөөр эхэлсэн. 4-р сарын 1-ий өдөр гэхэд өмнөх 7 хоногийн мөн үеэс 3.3 хувиар буурч 60000 төгрөг болсон бол 4-р сарын 8-нд өмнөх 7 хоногийн мөн үеэс 16.7 хувь буюу 10000

төгрөгөөр буурч 50000 төгрөг болов. 4-р сарын 15-ны өдөр өмнөх долоо хоногийн мөн үеэс 1 кг ноолуурын ханш 1000 төгрөгөөр өсч 51000 төгрөгт хүрлээ.



